



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 01333

Ховд

Хөрөнгө гаргах тухай.

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ариутгалын тасгийн эмч мэргэжилтнүүд, ажилтнуудын Баян-Өлгий аймагт харилцан туршлага судлах, үйл ажиллагаатай танилцахад 300 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 300 000 төгрөг /Гурван зуун мянган/ -ийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

